



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦЭЦЭРЛЭГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 12 өдөр

Дугаар А/25

Халбан

Бөхийн барилдаан зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Сумын аварга" шалгаруулах цолгүй залуу бөхийн барилдааныг 2024 оны 3 дугаар сарын 16-17-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. "Сумын аварга" шалгаруулах цолгүй залуу бөхийн барилдаан зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: М.Ренчиндорж (Засаг даргын Тамгын газрын Нярав)

Гишүүд: Н.Бямбасүрэн (Тэсийн-Эхийн хүчтэнүүд бөхийн холбооны тэргүүн)

Ч.Лхагва-Очир (Тэсийн-Эхийн хүчтэнүүд бөхийн холбооны дэд тэргүүн)

Н.Пүрэвжав (Аймгийн цоллооч, Засуул)

Х.Энхсүрэн (Эрүүл мэндийн төвийн дарга)

Ж.Азжаргал (Соёлын төвийн дарга)

Бүх багийн Засаг дарга нар

Нарийн бичгийн дарга: Н.Нямбаяр (Тэсийн-Эхийн хүчтэнүүд бөхийн холбооны нарийн бичиг)

3. "Сумын аварга" шалгаруулах бөхийн барилдаанд бөхчүүдийг өргөнөөр оролцуулж, үзэгч олны баясгасан, үнэнч шударга барилдаан зохион байгуулахыг ажлын хэсгийн гишүүдэд даалгасугай.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Бямбажав)-т үүрэг болгосугай.

ДАРГА  Н.АНХБАЯР

